

Living the LOTUS

Buddhism in Everyday Life



 *Үүсгэн байгуулагчийн сургаал* 

Хүлээн зөвшөөрөх хайрын үг

“Ямар ч эргэцүүлэл, бодож санах ч зүйлгүйгээр яаж ингэж чаддаг байнаа” гэж буруутгамаар нэгэн та бүхний эргэн тойронд байж магадгүй.

“Ямар гээч хүн бэ” гэж тэсгэл алдрах ч үе бий болов уу. Тэгвэл тэр хүний оронд өөрийгөө тавиад бодож үзээсэй гэж хүсэх байна.

Аягүй л бол тэр хүн эргэн тойрныхоо шүүмж, дайралтаас залхаж сэтгэлээ хаагаад, хэдэн давхар хуяг дуулгаар өөрийгөө хамгаалж байгаагаас гарцаагүй. Тийм байтал нэмэж зэмлэн, засаж залруулахыг хичээлээ ч гэсэн сонсох нь юу бол.

Сэтгэлийнхээ угаас “Ийм байж болохгүй” гэж өөрөө ухамсарлахгүй л бол хүн хичнээн үглэж дууллаа гээд өөрчлөгддөг юм биш.

Хамгийн чухал нь яавал цаад хүнээ жинхэнэ өөрөөр нь байлгах вэ, түүний төлөө хичээн зүтгэх явдал юм. Ингэхийн тулд өчүүхэн төдий зүйл дээр нөгөө хүнээ мэдэрч, ойлгож өгөхөд л хангалттай.

Зөрүүдлэн өөрийгөө хамгаалж байгаа хүний хамгийн их хүсдэг зүйл бол өөрийг нь ойлгох хүн гарч ирэх явдал юм.

“Хайрын үг” гэдэг нь эелдэг үг гэсэн утгатай боловч сэтгэл уяраах уран үг хэлж чадахгүй байлаа ч нөгөө хүндээ бүрэн итгэж, санал гомдлыг нь сэтгэлээсээ хүлээн зөвшөөрч өгвөл жинхэнэ хайрын үг болох болно.

Үүсгэн байгуулагчийн сургаал 9, Х.232-233

Living the Lotus Vol. 167 (2019,08)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Саитоо Коочироо

Орчуулсан: Ж.Сэлэнгэ

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутамдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Өөрийн “Эрхэм зүйл” -ийг гэрэлтүүлэх нь

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Өөртөө итгэхэд бэрх үе

Өөрийгөө болон гэр орноо бусад хүмүүс, бусад айлтай харьцуулаад өөртөө байхгүй зүйлийг нэхэх хүүхдэдээ зориулж эцэг эхчүүд: “Айл бол айл, манайх бол манайх” гэж их хэлдэг. Хүн бүр өөр өөрсдийн гэсэн амьдралаар явж буй тул бусадтай өөрийгөө харьцуулах хэрэггүй гэдгийг ойлгоход хялбараар илэрхийлсэн үг ч гэж хэлж болно.

Гэвч бусдад атаархах, бусадтай өөрийгөө харьцуулах нь хүний төрөлхийн зан ч байж магадгүй. Дутагдалтай байдлаа давуу тал болгон хичээн зүтгэсээр ур чадвараа харуулж, урагш ахин дэвшихийг зорьдог хүмүүс ч олон байдаг.

Бурханы сургаалд бусадтай өөрийгөө харьцуулах нь аливааг харах нүдийг харалган болгодог тухай өгүүлдэг. Хэсэг зуур бусдад атаархах сэтгэл төрлөө ч, түүнийгээ хэрэгцээ шаардлагаасаа давсан хүсэл шунал, ашиг тусгүй үзэн ядалт болтол нь дэврээлгүйгээр сэтгэл санаагаа хянах нь чухал.

Нөгөөтэйгүүр сүүлийн үед бусадтай өөрийгөө хэт харьцуулдаг байдлаасаа болоод амьдрах илтгэлээ алдан “Надад амьдрах утга алга” хэмээн хэтрүүлэн бодох хүмүүс их болоод байх шиг.

Цагаан Лянхуа Судрын “Сүслэн авахуйг үгүүлэх дөрөвдүгээр бүлэг”-т “Баян ноён ба ядуу хүүгийн зүйрлэл” гэсэн үлгэр бий. Энд гардаг “Ядуу хүү” бол дээрх хүмүүсийн нэг жишээ билээ. Тэнүүлчин амьдралаар амьдарч байсан өөрийг нь дэргэдээ авч, ажиллуулсан баян ноёныхоо итгэлийг олж, эрдэнэсийн агуулхыг нь хүртэл хариуцан ажиллаж байсан ч “Би бол энэ албанд тэнцэх хүн биш” гэсэн өөрийгөө голох бодлоосоо ангижирч чаддаггүй.

Одоо тэрхүү “Ядуу хүү” шиг өөртөө итгэлгүй гэх хүн ихэсч байгаа учир юу гэвэл хүсэл шуналыг нь өдөөсөн мэдээлэл хэт их цацагддаг болсноос, эдийн засгийн ялгаа, одоо хийж буй ажил нь ирээдүйд ашигтай юу үгүй юу зэргийг хялбархан таамаглах боломжтой цаг үе болохоор тэр болов уу.





Бурханлаг чанараа гэрэлтүүлэх

Жишээлбэл “Ядуу бол аз жаргалгүй бөгөөд хэцүү” гэсэн үнэлэмж байдаг гэж бодъё. Энэ бол эргэлзээтэй үнэлэмж. Улмаар энэ үнэлэмжийг өөртөө итгэх итгэл, хүсэл мөрөөдлийг үгүй хийх шалтгааны нэгд тооцлоо ч, иймэрхүү үнэлэмж дээр тулгуурласан “би бол азгүй хүн” хэмээх оношийг тавьж байгаа хүн бол та өөрөө юм. Хүний амьдрал “шүтэн барилдлагын хуулиар дотоод шалтгааны улмаас”-аас хамаараад яаж л бол яаж ч хувирч өөрчлөгддөг ба нэг л хэвээрээ байх зүйл гэж үгүй. Тийм байтал өөртөө нэг л янзын шошго наачихаад шаналан зовж, өөртөө итгэх итгэл, хүсэл мөрөөдлөө алдана гэдэг бол оноогдсон амь насанд дэндүү хайран гэж бодож байна.

Бусадтай өөрийгөө харьцуулах нь өсөн дэвших мэдрэмжийн нөгөө тал нь юм. Сэтгэлийнхээ гүнд “Илүү сайхан амьдрах юмсан” гэсэн хүсэл байгаа болохоор л дутагдах сэтгэл урган гарч ирдэг хэрэг.

Харин өөрийнхөө аз жаргалгүй байгаа шалтгааныг хорвоо ертөнц болон бусдаас хайж, тэр бодолдоо автах юм бол өсөлт хөгжлийн үр болох ёстой “бусадтай өөрийгөө харьцуулах үзэл” нь гомдол цөхрөлийн үр болж хувираад, хөгжил дэвшилд хөтлөхгүй болж орхино. Дээр өгүүлсэн “Сүслэн авахуйг үгүүлсэн бүлэг”-ийн “Ядуу хүү”-ийн тухайд баян ноён амьсгал хураахын өмнө цугласан олны өмнө ингэж хэлжээ.

“Энэ залуу бол бага байхдаа сураггүй болсон миний хүү билээ. Эд хөрөнгө минь бүгд түүнийх.”

Энэ бол өөрийгөө голж байсан “Ядуу хүү”-гийн хувьд өөрийнхөө үнэт зүйлийг олж анзаарах мөч байсан юм. Мөн ноёны хэлсэн үгний цаад санаа нь “үнэндээ бүх хүн бурханы хүүхэд бөгөөд бурхантай ижил үнэ цэнэтэй бурханлаг чанарыг тээдэг. Тиймээс өөртөө эргэлзэлгүй, итгэл дүүрэн өөрт буй эрхэм зүйл(бурханлан чанар)-ээ гэрэлтүүлээрэй” хэмээх утгатай юм.

Улмаар зөвхөн өөрийнхөө эрхэм зүйлийг анзаараад баярлах бус, хараахан түүнийгээ мэдэхгүй байгаа хүмүүст өөрийнхөө анзаарсан, мэдсэн зүйлээ хэлж дамжуулж, тэр хүнийхээ “эрхэм зүйл”-ийг гэрэлтүүлэх учрал нь болсноор таны өөрийн “бурханлаг чанар” улам тодрох болно гэдгийг эндээс сурч авлаа.

Бурханы сургаалд итгэж, ойлгохыг “сүслэх ба ойлгох” гэж хэлэх ба хүмүүс бүгд ижил тэнцүү “Бурханлаг чанар” хэмээх үнэт эрдэнэстэй гэдэгт “Итгэж, ойлгож”, өөртөө итгэлтэйгээр амьдарцгаая.

«Косей»2019 оны 8 дугаар сарын дугаар



Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар

Номын багш хэмээх 10 дугаар бүлэг (Эхний хагас)



Номын багш гэж хэн бэ?

Номын багш гэдэг нь зөвхөн сахил хүртсэн лам хүнийг л хэлдэг биш. Бусдын төлөө Бурханы номыг айлдах хүн бүр Номын багш юм. Энэ бүлэгт тэрхүү номын багш хэрхэн сэтгэл санаагаа удирдан чиглүүлэх вэ, мөн цөвүүн цагт амьдрах бид ямар сэтгэлээр ном айлдвал зохилтой тухай, мөн номыг зөв таниулж түгээснээр ямар буян хүртэх тухай өгүүлэх бөгөөд бидний сүсэг бишрэлт амьдралтай нарийн сэжмээр холбогдох маш чухал бүлэг юм.

Юун түрүүнд анхаарах шаардлагатай зүйл бол Шагжамүни Бурханы сургаалыг сонсох гол субъект буюу бай нь энэхүү бүлгээс орвонгоороо өөрчлөгдөж Бодисадва болдог хэсэг. Өнөөг хүртэл Ширваган, БрадигаБудда ба Бодисадва нар нь хоорондоо ялгаатай хэмээх үзэл бодол хүмүүсийн сэтгэлд бат тогтсон байсан бол “Суралцагч, үл суралцагчийн тухай өгүүлэх 9 дүгээр бүлэг” хүртэлх Бурханы сургаалд Шагжамүни Бурхан бээр “Тийм ялгаа угаас байхгүй бөгөөд бүгд Бодисадва, бүгд Бурхан багш болох замаар явж буй.” хэмээн дахин давтан айлдаж, түүнийхээ баталгаа болгож олон ширвагануудад (БрадигаБудда ч үүнд багтана) Бурхан болно гэсэн иш үзүүлдэг.

Тиймээс цаашид Бурхан багшийн сургаалыг сонсогч нь бүгд Бодисадва болно гэсэн үг юм. Өөрөөр хэлбэл Бурханы сургаалыг сонсож буй хүн нь өмнөхтэйгээ адил байлаа ч сонсох сэтгэл нь өөрчлөгдсөнөөр амьдралд баримтлах зарчим, үнэлэмж нь ч гэсэн орвонгоороо өөрчлөгдөнө гэсэн үг. Тиймээс Шагжамүни Бурхан сургаалаа айлдахдаа өнөөг хүртэл “Шаарийбүү!”, “Махакаашяпа аа!”, “Олон аяга тэхимлигүүд ээ!” зэргээр дуудаж байсан нь хойшид “Оточийн хаан Бодисадва минь ээ!”, “Манзушир Бодисадва аа!”, “Олон Бодисадва нар аа!” болж өөрчлөгддөг байна.



Хамгийн анх төрсөн баяр баясал

Эхлээд Шагжамүни Бурхан “Хэрвээ миний айлдах Оройн дээд лянхуа судрын нэг бадаг нэг мөрийг ч болов сонсоод хормын дотор “Юутай талархмаар” хэмээн сэтгэлээсээ бодох хүн байвал би түүнд Бурханы хутгийг олж чадна гэсэн баталгаа өгнө. Учир нь тэр хүн гарцаагүй Бурханы гэгээрлийг олох нь дамжиггүй юм” хэмээн айлдана. Жирийн ертөнцөд ч тэр, агуу зүйлийг хараад ямарч эргэлзээгүй хүүхэд шиг гэнэн сэтгэлээр баярлан хөөрдөг хүн л их амжилтанд хүрдэг олон бодит жишээ бий. Харин өөрт ашигтай юу гэсэн өнцгөөс л юмыг хардаг хүн бол ялимгүй амжилт болон багахан байр сууринд хүрлээ ч агуу зүйлд хүрч чаддаггүй. Түүхэнд үлдэх гавъяа байгуулах боломжгүй.

Улмаар сүсэг бишрэлт амьдралын хувьд ч тэр адил. Бурханы сургаал бол агуу зүйлсийн дотроос хамгийн агуу нь билээ. Тэрхүү Бурханы сургаалыг сонсоод үнэн сэтгэлээсээ догдолж, итгэх юм бол тэр хүн гарцаагүй хязгааргүйгээр дэвжин дээшилж чадах дотоод мөн чанартай хүн юм.

Хүсэж төрөх

Учир нь тэр хүн “Хамаг амьтныг энэрэн нигүүлсэхийг хүсэж энэ ертөнцөд төржээ” гэсэн болохоор юм. Өөрөөр хэлбэл Бодисадва бол Бурхан будда болох боломжтой атлаа, диваажинд төрөх боломжоо гээгээд, хамаг амьтныг нигүүлсэнгүй сэтгэлээр өрөвдөхийн эрхэнд өөрөө хүсэж энэ ертөнцөд (Хүн болж) төрсөн гэдэг. Сайн муу үйлийн үрээрээ шүүгдэж, дахин мэндлэх бус хамаг амьтныг аваръя гэсэн хүсэл болон энэрэнгүй сэтгэлийн үндсэн дээр дахин төрсөн гэсэн үг юм.

Тиймээс “Би бол Бодисадва болж энэ ертөнцөд ирсэн” гэдгээ ухамсарлаж, Бодисадвагийн үүднээс аливаад хандах боломжтой. Учир нь Бурхан болон Бодисадва нь өөрийн хүссэн ямар ч биед хувиран, ямар ч газар төрж чаддаг. Өөрөөр хэлбэл ямарч “Хувилгаан дүр”-д хувилж чадах учраас тэр билээ. Улмаар энэ ертөнцөд сэтгэлээсээ Цагаан Лянхуа Судрын сургаалыг хүлээн авч, нэгэн биеэ зориулан түүнийг айлдан түгээгч хүний бодит бие нь бусдаас ялгарахгүй жирийн хүн шиг харагдах хэдий ч тэр бол Бурхан, Бодисадва энэ ертөнцийг аврахын тулд биеэ хувирган ирсэн хэмээн бодвол зохино. Тэгээд тийм хүнийг хамгийн ихээр дээдлэн хүндэтгэх хэрэгтэй.

Улмаар бид өөрсдөө түүнийг ухамсарлах нь чухал. Ийм ухамсар бол огтхон ч онгиороо сагсуу бус харин ариун ухамсар билээ. Үнэхээр тийм ариун мэдрэмжтэй болох юм бол олиггүй муу үг үйлдэл зэргийг хийж чадахгүй болох болно. Аяндаа л бусдын төлөө, энэ ертөнцийн сайн сайхны төлөө амьдрахаас өөр аргагүй болох болно. Зөвхөн жирийн нэг ариун байдал төдийгүй сэтгэл зүрхний угаас ундрэн гарах ямар нэг зүйлд хөтлөгдөж, байгалиасаа энэрэнгүй, нигүүлсэнгүй үйлдэл болон Цагаан Лянхуа Судрыг түгээн дэлгэрүүлэхэд бие сэтгэлээ зориулахаас өөр аргагүй болох болно. Тэр бол яалт ч үгүй Бодисадвагийн түвшин мөн билээ.



Баяр баяслыг уртасгах ном ба бясалгал

Бодисадвагийн энэхүү ухамсар нь хормын төдийд “Талархмаар” хэмээх сэтгэлээс үүдэлтэй “Хормын баяр баясал”-аас эхлэлтэй. Гэвч энэхүү баяр баяслаа хормын дотор дуусгалгүй үргэлжлүүлэн явснаар илүү бодитой, баталгаатай ухамсар болон төлөвших болно. Өөрөөр хэлбэл тэр хормыг уртасгаж, сэтгэлдээ хоногшуулж байж л “Хормын баяр баясал” гэх зүйл түүний жинхэнэ үнэ цэнэтэй зүйл болон хувирах болно.

Тэгвэл “Хормын баяр баясал”-ыг юу хөгжүүлэх вэ... Тэр бол ном ба бясалгал.

Ном гэдэг нь Бурхан багш болон түүний сургаалд талархлын үнэн сэтгэлээр хандаж, мөргөл хийгээд бусад үйлээр дамжуулж чин сэтгэлээ илэрхийлэх явдал юм.

Нивано Никкёо “Лянхуан Гурамсан Сударын бүлэг тус бүрийн тайлбар /шинэ хэвлэл/”, Косей хэвлэлийн компани, 2016, X. 99-104

Living the
 **LOTUS**

Бусдын бурханлаг чанарыг олж нээцгээе!

Энэ сарын сургаал дээрээ Нивано ерөнхийлөгч “Баян ноён ба ядуу хүүгийн үлгэр”-ийг иш татсан байна.

Бусдаас өөрийгөө доогуур үнэлж, өөрийгөө голж, өөртөө итгэлгүй байдаг хүн өнөө үед олон болоод байгаа. Гэвч “Баян ноён ба ядуу хүүгийн үлгэр”-т бид бүгд бурханы хүүхдүүд гэж гардаг. Бүх хүнд гялалзан гэрэлтэх, бурханлаг чанар бий гэсэн үг юм. Тиймээс өөрт болон өрөөлд байгаа тэрхүү бурханлаг чанарт итгэн сүсэглэж (сүсгээрээ итгэж, толгойгоороо ойлгох), өөртөө итгэлтэйгээр амьдрах хэрэгтэй.


Бодисадва нарын үүрэг бол өөрөөсөө гадна эргэн тойрны бүхий л хүмүүст хүсэл эрмэлзэл, баяр хөөрийг түгээх учрал нь болох явдал юм.

Үүний тулд сургаалаас дахин дахин суралцаж, амьдрал ахуйдаа шантралгүй хэрэгжүүлж, өөрийн доторх эрдэнэсийг олж хардаг болохын төлөө хичээцгээе.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Саитоо Коичи



Rissho Kosei-kai: A Global Buddhist Movement



Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, USA
 TEL: 1-808-455-3212 FAX: 1-808-455-4633
 Email: info@rkhawaii.org URL: <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, USA
 TEL: 1-808-242-6175 FAX: 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona, HI 96740, USA
 TEL: 1-808-325-0015 FAX: 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, USA
 POBox 33636, CA 90033, USA
 TEL: 1-323-269-4741 FAX: 1-323-269-4567
 Email: rk-la@sbcglobal.net URL: <http://www.rkina.org/losangeles.html>

Please contact Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

- Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**
- Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**
- Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, USA
 POBox 778, Pacifica, CA 94044, USA
 TEL: 1-650-359-6951 FAX: 1-650-359-6437
 Email: info@rksf.org URL: <http://www.rksf.org>

Please contact Rissho Kosei-kai of San Francisco

- Rissho Kosei-kai of Sacramento**
- Rissho Kosei-kai of San Jose**

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016, USA
 TEL: 1-212-867-5677 Email: rknny39@gmail.com URL: <http://rk-ny.org>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, USA
 TEL: 1-773-842-5654
 Email: murakami4838@aol.com URL: <http://rkchi.org>

Rissho Kosei-kai of Fort Myers

URL: <http://www.rkftmyersbuddhism.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th St., Oklahoma City, OK 73112, USA
 POBox 57138, Oklahoma City, OK 73157, USA
 TEL: 1-405-943-5030 FAX: 1-405-943-5303
 Email: rkokdc@gmail.com URL: <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai Dharma Center of Denver

1255 Galapago St. #809 Denver, CO 80204, USA
 TEL: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

617 Kling Drive, Dayton, OH 45419, USA
 URL: <http://www.rkina-dayton.com>

The Buddhist Center Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First St., Suite #1, Los Angeles, CA 90033, USA
 TEL: 1-323-262-4430 FAX: 1-323-262-4437
 Email: info@rkina.org URL: <http://www.rkina.org>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

(Address) 6083 Babcock Road, San Antonio, TX 78240, USA
 (Mail) POBox 692042, San Antonio, TX 78269, USA
 TEL: 1-210-561-7991 FAX: 1-210-696-7745
 Email: dharmasanantonio@gmail.com
 URL: <http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, USA
 TEL: 1-253-945-0024 FAX: 1-253-945-0261
 Email: rkseattlewashington@gmail.com
 URL: <http://buddhistlearningcenter.org>

Rissho Kosei-kai of Vancouver

Please contact RKINA

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP, CEP 04116-060, Brasil
 TEL: 55-11-5549-4446, 55-11-5573-8377
 Email: risho@rkk.org.br URL: <http://www.rkk.org.br>

Facebook: <https://www.facebook.com/rishokosseikaidobrasil>
Instagram: <https://www.instagram.com/rkkbrasil>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP, CEP 08730-000, Brasil

在家佛教韓國立正佼成會

〒 04420 大韓民國 SEOUL 特別市龍山區漢南大路 8 路 6-3
6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
TEL: 82-2-796-5571 FAX: 82-2-796-1696

在家佛教韓國立正佼成會釜山支部

〒 48460 大韓民國釜山廣域市南區水營路 174, 3F
3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
TEL: 82-51-643-5571 FAX: 82-51-643-5572

社團法人在家佛教立正佼成會

台灣台北市中正區衡陽路 10 號富群資訊大廈 4 樓
4F, No. 10, Hengyang Road, Jhongheng District, Taipei City 100, Taiwan
TEL: 886-2-2381-1632, 886-2-2381-1633 FAX: 886-2-2331-3433

台南市在家佛教立正佼成會

台灣台南市崇明 23 街 45 號
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701, Taiwan
TEL: 886-6-289-1478 FAX: 886-6-289-1488
Email: koseikaitainan@gmail.com

Rissho Kosei-kai South Asia Division

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsikhel, Sanepa-1, Lalitpur, Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059, West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road, Rumpur, Gaya-823001,
Bihar, India

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Central Delhi

77 Basement D.D.A. Site No. 1, New Rajinder Nagar,
New Delhi 110060, India

Rissho Kosei-kai of Singapore

Rissho Kosei-kai of Phnom Penh

W.C. 73, Toul Sampaov Village, Sangkat Toul Sangke, Khan Reouseykeo,
Phnom Penh, Cambodia

RKISA Rissho Kosei-kai International of South Asia

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8141 FAX: 66-2-716-8218

Rissho Kosei-kai of Bangkok

Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkok, Huaykhwang, Bangkok 10310, Thailand
TEL: 66-2-716-8216 FAX: 66-2-716-8218 Email: info.thairissho@gmail.com

Rissho Kosei Dhamma Foundation

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
TEL: 94-11-2982406 FAX: 94-11-2982405

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Rissho Kosei-kai Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
TEL/FAX: 880-31-626575

Rissho Kosei-kai Mayani

Mayani Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Damdama

Damdama Barua Para, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Patiya

China Clinic, Patiya Sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Satbaria

Village: Satbaria Bepari Para, Chandanaih, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai Chendhirpuni,

Village: Chendhirpuni, P.O.: Adhunogar, P.S.: Lohagara, Chittagong,
Bangladesh

Rissho Kosei-kai Dhaka

408/8 DOSH, Road No 7 (West), Baridhara, Dhaka, Bangladesh

Rissho Kosei-kai Laksham

Village: Dhupchor, Laksham, Comilla, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar

Ume Burmize Market, Tekpara, Sadar, Cox's Bazar, Bangladesh

Rissho Kosei-kai Cox's Bazar, Ramu Shibu

Rissho Kosei-kai Raozan

Dakkhin Para, Ramzan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Buddiyskiy khram "Lotos"

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk 693005, Russia
TEL: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point, Hong Kong, China

Rissho Kosei-kai Friends in Shanghai

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

(Address) 15F Express Tower, Peace avenue, khoro-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia

(Mail) POBox 1364, Ulaanbaatar-15160, Mongolia

TEL: 976-70006960 Email: rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Erdenet

2F Ikh Mandal building, Khurenbulag bag, Bayan-Undur sum,
Orkhon province, Mongolia

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29, 00184 Roma, Italia

TEL/FAX: 39-06-48913949 Email: roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Paris

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai International Buddhist Congregation (IBC)

166-8537 東京都杉並区和田 2-7-1 普門メディアセンター 3F

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537, Japan

TEL: 03-5341-1230 FAX: 03-5341-1224 URL: <http://www.abc-rk.org>